

Коронавируст халдвараас сэргийлэх вакцинжуулалтанд хамрагдсан зорилтот бүлгийн иргэдийн вакцины талаарх мэдлэг, хандлагыг судалсан үр дүн

Г.Уугантуяа¹, Г.Азжаргал², Б.Батболд³

¹Увс аймгийн Эрүүл мэндийн газар

²Халдварт өвчин судлалын үндэсний төв

³Т.Шагдарсүрэнгийн нэрэмжит Анагаах Ухааны Хүрээлэн, АШУУИС

e-mail: Uugantuya.gantulga@gmail.com, 99818933

Abstract

Knowledge and attitudes of Covid-19 vaccine in the target population vaccinated against coronavirus infection

Uugantuya L¹, Azjargal G², Batbold B³

¹Health department of Uvs province

²National center for communicable diseases

³Institute of medical sciences, MNUMS

Introduction: According to the World Health Organization, 251 vaccines against coronavirus infection are under development. Although vaccination has been introduced nationwide to prevent coronavirus infection, vaccine activity varies (50-95%), and the risk of infection and complications may vary depending on the individual's physical condition and immune activity. In addition, due to the prevalence of variant of concern, which reduces the activity of some vaccines and increases the risk of complications and mortality of COVID-19, each country and region needs to improve the knowledge and attitudes of citizens about the vaccine. there is a need to study.

Goal: To study the knowledge and attitudes of people who have been vaccinated against COVID-19 among the target population of Uvs province.

Materials and methods: The study was conducted using a descriptive method of observational research. Quantitative and qualitative methods were used to collect the survey data, and the data were collected in April 2021 through a questionnaire. A random sample of 4,212 people from 11 organizations involved in the Covid-19 vaccine was randomly selected from 24 organizations, and a total of 264 people were surveyed using 12 types of Covid-19 vaccine and analyzed using SPSS software.

Result: According to the results of the survey, 4212 people from 11 organizations and 24 people from each organization were randomly selected from a total of 264 people. Mostly female participants (57.5%) have been included in this study. 67.4% of the respondents reported that they do not feel fear associated with vaccination and it means that most of the participants did not show any signs of panic. 91.2% participants did not have any symptoms after the vaccination. 30.4% from total participants was used anti-inflammatory or pain relief pills after vaccination at home. 45.8% of the respondents self reported that they have moderate knowledge about Covid-19 vaccine

Conclusion: Overall knowledge of people from Uvs province was insufficient. However, attitude was good enough.

Key words: Covid 19, vaccine, knowledge and attitude, questionnaire, Uvs province

Pp. 87-89. Figures 2, References 15

Үндэслэл:

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг [1, 2], Гамшгаас хамгаалах хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.5 дахь заалт [3], Дархлаажуулалтын тухай

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 11.1, 11.2, 14.1 дэх заалтын дагуу [4, 5] тархвар судлалын заалтаар вакцинжуулах ажлыг улс орон даяар эхлүүлээд байна.байна [6, 7]. Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор улс

орон даяар вакцинжуулалтыг эхлүүлээд байгаа хэдий ч вакцины идэвхи харилцан адилгүй (50-95%), хувь хүн бүрийн өвөрмөц биеийн байдал, дархлааны идэвхээс хамаарч халдвар авах, хүндрэх эрсдэл өөр өөр байх боломжтой ажээ. Мөн түүнчлэн зарим вакцины идэвхийг бууруулдаг [8, 9], Ковид-19 өвчлөлийн хүндрэл, нас баралтыг нэмэгдүүлдэг вирусын мутацид орсон аюултай хувилбарууд [10] (VOC – variant of concern) нь дэлхий дахинд олон улсад тархаж байгаа [11] зэргээс хамаарч улс орон, бүс нутаг бүр иргэдийн вакцины талаарх мэдлэг, хандлагыг сайтар судлах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Зорилго: Увс аймгийн эрсдэлт бүлгийн хүн амын дунд хийж буй Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд хамрагдсан иргэдийн мэдлэг, хандлагыг судлах.

Судалгааны ажлын зорилт:

1. Увс аймгийн эрсдэлт бүлгийн хүн амын дунд хийж буй Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд хамрагдсан иргэдийн мэдлэгийг судлах.
2. Увс аймгийн эрсдэлт бүлгийн хүн амын дунд хийж буй Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд хамрагдсан иргэдийн хандлагыг судлах.

Материал, арга зүй: Ажиглалт судалгааны дескриптив аргаар судалгааг хийсэн. Судалгааны мэдээллийг цуглуулахдаа тоон болон чанарын аргыг хэрэглэж, мэдээллийг 2021 оны 4 дугаар сард асуумж бөглүүлэх аргаар цуглуулсан. “Ковид-19”-ын эсрэг вакцинд хамрагдаж буй 11 байгууллагын 4212 хүнээс санамсаргүй түүврийн аргаар байгууллага бүрээс 24 хүн, нийт 264 хүнээс 12 төрлийн “Ковид-19”-ын эсрэг вакцинтай холбоотой боловсруулсан асуумж авч SPSS программ дээр боловсруулалт хийсэн.

Судалгааны ажлын ёс зүй: Судалгаанд хамрагдсан хүмүүст судалгааны зорилго, ач холбогдлыг танилцуулж, судалгаанд өөрийн хүсэлтээр оролцох, аль ч үе шатанд судалгаанаас татгалзах эрхтэй бөгөөд мэдээллийг зөвхөн эрдэм шинжилгээний зорилгоор ашиглахыг тайлбарлаж, зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зуруулж баталгаажуулсны үндсэн дээр судалгааг хийж гүйцэтгэсэн.

Үр дүн: Тархвар судлалын заалтаар Увс аймгийн зорилтот бүлгийн Ковид-19-ийн вакцинд хамрагдсан хүн амаас түүвэрлэн авсан

264 хүнийг хүйсийн харьцаагаар авч үзэхэд 42.5% эмэгтэй, 57.5% эрэгтэй хүн байлаа. Насны хувьд судалгаанд хамрагдагчдын 21-30 нас 10.9%, 31-40 нас 14.7%, 41-50 нас 21.4%, 51-60 нас 25%, 61-70 нас 28% тус тус эзэлж байна.

Та хийлгэж буй Ковид-19-ийн вакцины талаар хэр их мэдээлэлтэй байна вэ? гэсэн асуултанд 45.8% дунд зэрэг, 21.3% огт мэдэхгүй, 17.4% муу мэдлэгтэй байна гэж хариулжээ.




Figure 1. Self-reported overall knowledge about Covid-19 vaccine

Ковид-19-ийн вакцин тариулахтай холбоотой танд айх, сандрах ямар нэгэн мэдрэмж төрж байна уу? гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 67.4% айж сандарсан мэдрэмж байхгүй, 14.7% айж сандарч байна, 17.9% хэлж мэдэхгүй байна гэж хариулсан.

Танд вакцинжуулалтанд хамрагдах сонирхол байна уу? гэсэн асуултанд нийт судалгаанд оролцогчдын 91.6 хувь нь тийм, 8.4 хувь нь үгүй гэж хариулжээ.

Ковид-19-ийн вакцины I тунг хийлгэсний дараа таны биед ямар нэгэн шинж тэмдэг илэрсэн үү? гэсэн асуултанд нийт судалгаанд оролцогчдын 84.3% тийм, 15.7% үгүй гэж хариулсан байна.




Figure 2. Symptoms after Covid-19 vaccination

Хэрэв тийм бол дээрх шинж тэмдгүүдээс аль нь илэрсэн бэ? гэсэн олон сонголттой асуултанд

нийт судалгаанд оролцогчдын 91.2% ядрах сульдах, 89.4% толгой эргэх, өвдөх, 84.3% бие эвгүй оргих, 78.2% халуурах, ханиах зэрэг шинж тэмдгүүд илэрсэн байна.

Хэлцэмж: Увс аймгийн иргэдийн ихэнх нь Ковид-19-ийн эсрэг вакцинд хамрагдах сонирхолтой байсан нь харагдаж байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд судалгаанд оролцогчдын дийлэнхид нь айж сандарсан ямар нэг шинж тэмдэг илрээгүй байна. Мөн судалгаанд оролцогчид Ковид-19-ийн эсрэг вакцин тариулахдаа харьцангуй тайван байсан байна. Израиль улсад үндэсний тандалтын өгөгдлийг ашиглан хийсэн ажиглалт судалгааны зарим үр дүнд судалгаанд оролцсон иргэдийн вакцин хийлгэсний дараа халуурсан, ханиасан гэх мэт амьсгалын замын шинж тэмдэгүүд илэрч байсан [12, 13] нь бидний судалгааны 91.2% нь ядрах сульдах, 89.4%-д нь толгой эргэх, өвдөх, 84.3%-д нь бие эвгүй оргих, 78.2 %-д нь халуурах, ханиах зэрэг шинж тэмдэгүүд илэрсэн үр дүнтэй дүйж байна [14, 15].

Дүгнэлт: Судалгааны үр дүнгээс харахад Увс аймгийн иргэдийн дунд Ковид-19-ийн вакцины талаарх мэдлэг хангалтгүй байна. Гэсэн хэдий ч Ковид-19-ийн вакцинд хандах хандлага сайн байгаа нь ажиглагдлаа. Судалгаанд оролцогчдын дунд вакцины хариу урвал харьцангуй бага хувьтай илэрсэн.

Санал, зөвлөмж:

1. Хийж буй вакцины талаар иргэдэд үнэн зөв мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим хэлбэрээр тогтмол хүргэх
2. Вакцин хийлгэсний дараа тухайн хүний биед илрэх шинж тэмдгийн талаарх мэдээллийг тухай бүрт нь хэлж, тайлбарлаж өгөх
3. Вакцин хийлгэсний дараа ямар нэгэн шинж тэмдэг илэрвэл гэрээр хэрхэн эмчлэх талаар зөвлөх

Ном зүй

1. Увс ЭМГ. Шинэ коронавируст (covid-19) халдвар орж ирсэн үед тархах эрсдэлийн салбар дундын 6 дахь үнэлгээ. 2021.х.2.
2. Увс ЭМГ. Шинэ коронавируст (covid-19)

халдвар орж ирсэн үед тархах эрсдэлийн салбар дундын 6 дахь үнэлгээ. 2021.х.3.

3. ЭМЯ.2021 [01 сар 21] <https://monmap.maps.arcgis.com/apps/opsdashboard/index>.
4. Увс аймаг. шуурхай штабын тэмдэглэл. 2021.х.1
5. ЭМЯ. 2021 [01 сар 21] <https://covid19.mohs.mn/>
6. Priscilla Idele, Amaya Gillespie, Tyler Porth, Chiho Suzuki. Epidemiology of HIV and AIDS Among Adolescents. 2014 July 1:Supple 2.
7. ЭМЯ, Олон улсын хөгжлийн газар. Эхээс урагт халдвар дамжихаас сэргийлэх удирдамж. Улаанбаатар: 2001. х. 2.
8. UNAIDS Report on the Global AIDS Epidemic 2010. 2010.
9. Оюунболор Н. Мөнхтүвшин Н. Лхагвасүрэн Б. Улаанбаатар хотын дотуур байранд амьдардаг оюутны нийгэм сэтгэл зүйн чанарын судалгаа. Улаанбаатар: 2008.
10. Mary Mahy, Susan Kasedde, Chewe Luo. Hiv programe achieving our goals operational plan 2014-2015. Switzerland: 2014
11. Эрүүл мэндийн сайдын тушаал. 2014 [4 сар 14].<http://www.moh.mn/index>.
12. ЭМЯ, НҮБ-ын хүн амын сан, МНЭНМН, ICOMP. НҮЭМ-ийн хөтөлбөрийн удирдлага. Улаанбаатар: 2004.х.9.
13. ЭМЯ, НҮБ-ын хүн амын сан, МНЭНМН, ICOMP модуль 7. НҮЭМ-ийн хөтөлбөрийн хяналт шинжилгээ ба үнэлгээ. Улаанбаатар: 2004. х.16.
14. Инновацийн талаарх ойлголт. 2015 [5 сар 16]. <http://tech.news.mn/content/>.
15. Пүрэв Ц. Чанарын судалгаа. Улаанбаатар: 2013.

Танилцаж нийтлэх санал өгсөн: АУ-ны доктор, дэд профессор Л.Тулгаа